

ТАНИЛЦУУЛГА

Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэгт заасны дагуу 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш төрсөн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2023 оны үлдэгдэл, 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 2023 оны инфляцын түвшин, Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.20-д заасан арилжааны банкнаас албан ёсоор зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх жилийн дундаж хүүгийн хэмжээг тус тус баримтлан тооцлоо.

Инфляцын түвшин

Нэр	2023 он
Инфляцын түвшин	7.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны вэб сайт 1212.mn

Арилжааны банкны иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх жилийн дундаж хүүгийн хэмжээ

Банкны нэр	Төгрөгийн 1 жилийн хугацаатай энгийн хадгаламжийн 2023 оны хүүгийн хэмжээ	Дундаж хүүгийн хэмжээ
Хаан банк	12.3%	12.2%
Төрийн банк	12.3%	
Хас банк	11.5%	
Худалдаа хөгжлийн банк	12.5%	
Голомт банк	12.4%	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, арилжааны банкнуудын вэб сайт болон lemonpress.mn

Хуулийн дээрх заалтын дагуу тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 10.05 хувиар тооцож 2025 оны 01 дүгээр сард Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлсэн. Уг хуралдаанаар тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээ, тооцсон аргачлалд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооноос дүгнэлт гаргуулахаар буцаасан.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооноос дараах дүгнэлтийг гаргасан:

- Хууль тогтоомжид нийцүүлэн “Тэтгэврийн даатгалын нэрийн дансны орлогод хүү тооцох аргачлал”-ыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулж, мөрдөх;
- Инфляцын түвшин болон арилжааны банкнуудын иргэдийн хугацаатай хадгаламжийн хүүг дундажлах бус харгалзан үзэж тогтоох.

Дээрх дүгнэлтийн дагуу Мэргэжлийн хорооноос Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүг банкны системд нөлөө бүхий арилжааны банкнуудаас албан ёсоор зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн өнгөрсөн оны дундаж хүү 12.2% байгааг баримтлах нь зүйд нийцнэ гэсэн саналыг гаргасан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооноос ирүүлсэн дүгнэлт, саналыг тусган даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2023 оны үлдэгдэл, 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Журам батлах тухай” 01 дүгээр тогтоолоор баталсан “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ын 5.2-т заасан нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тооцох томъёоны дагуу 2023 оны инфляцын түвшин, арилжааны банкнаас албан ёсоор зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн 2023 оны жилийн дундаж хүүгийн хэмжээг тус тус үндэслэсэн дараах байдлаар тооцсон болно. Үүнд:

$$X = A * И + Б * Д$$
$$A + Б = 1$$

X-тухайн онд нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээ;

И-өмнөх оны инфляцын түвшин;

Д-Банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3.1.20 дахь хэсэгт заасан арилжааны банкнаас албан ёсоор зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх оны жилийн дундаж хүүгийн хэмжээ;

A-инфляцын түвшингээс сонгох хувь хэмжээ;

Б-иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх оны жилийн дундаж хүүгийн хэмжээнээс сонгох хувь хэмжээ.

Нэрийн дансны 2024

оны орлогод тооцох = $0.8 * 7.9 + 0.2 * 12.2 = 11.34$

хүүгийн хэмжээ

Дээрх тооцооллын дагуу нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээ тооцсон танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлсэн.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.34 хувиар тогтоохыг дэмжсэн, Үндэсний статистикийн хорооноос инфляцын түвшин, иргэдийн мөнгөн хадгаламжийн хувь хэмжээнээс сонгох хувь хэмжээг хэрхэн тооцох талаар тодорхой тусгах саналтай байгаа талаар албан бичиг ирүүлсэн.

Энэхүү тооцоог үндэслэн Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.34 хувиар тогтоох саналтай байна.

---oOo---